

5

## **МОНГОЛ УЛСЫН ГАДААД ӨРИЙН ШИНЖИЛГЭЭ**

С.Дөлбадрах

## 1. ТАНИЛЦУУЛГА

Ямар нэг улсын хувьд бусад улсууд болон олон улсын байгууллагад өртэй болж өр ба дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа нь зохистой түвшингээсээ хэтэрч өрийн дарамт шахалт, хараат байдалд орох нь эдийн засгийн аюулгүй байдалд нелөөлөгч нэг гол хүчин зүйл болдог. Учир нь:

**нэгдүгээрт**, орчин үеийн эдийн засгийн аюулгүй байдлыг хангах хамгийн гол үзүүлэлт болох бусад улсуудтай харилцан хамааралтай оршиж чадахгүй болно.

**хоёрдугаарт** урсгал тооцооны алдагдал зохистой түвшнээсээ хэтэрч эдийн засгийн тогтолцооны тогтвортой, бие даасан байдлын хангах макро эдийн засгийн бодлого хэрэгжиж чадахгүйд хурдэг.

Хөгжих буй орнуудын санхүүгийн бүтэц гадаадын капиталаас хамаарч байх үед тэдгээрийн капиталын нийлүүлэлт мөн л гадаад өрийн тогтвортой байдлын баталгаа болж байдаг олон улсын хүрээлэн буй орчноос хамааралтай байдал. Энэ тогтвортой байдал гэсэн ойлголт нь хөгжих буй орнуудыг төлбөрийн тэнцлийн хямралаас зайлцуулахад ашиглаж болох нэг чухал зүйл болж өгдөг.

Ургал тооцооны алдагдал, гадаад өрийн өртөг болон гадаад зээлийн хүүгийн түвшнүүд нь урт хугацаанд гадаад өрийн тогтвортой төлөв буюу валютын ханшны хямралд хүргэж чаддаг.

Гадаад өрийн загваруудыг урсгал тооцоо, худалдааны тэнцэл болон ДНБ-ын оролцуулан бүтээснээр капитал тооцооны илүүдлийг тогтвортойгоор хадгалах санхүүгийн хэврэг байдалтай байна уу, эсвэл капитал тооцоо "Ponzi" санхүүгийн нэхцэлтэй байна уу гэдгийг илрүүлэх боломжийг олгодог. Мөн үүнээс гарсан ү

дун нь санхүүгийн либеральчлалын здийн засгийн бодлогын утга санааг шинжлэхэд тус болдог.

Капиталын дотогшлох бүрсгал зүйн баталгаатай макро эдийн засгийн тогтвортруулалт шиг өсөлт дэх богино хугацааны саад тогтороос зугтааж чадагч ялангуяа хөгжих буй эдийн засгуудын хувьд эдгээр урсгалуудын тохируулга нь хүнд хэцүү байдаг ба “хутганы-ир”-ны замд хүргэж болдог.

Капиталын дотогшлох ургалын макро зэдийн засгийн удирдлага нь богино хугацааны макро зэдийн засгийн нэг амжилттай бодлого байдаг ч гэсэн гадаад хадгаламж үргэлжийн, дуусашгүй байх нь тодорхойгүй байдгаас гадаад өрийг санхүүжүүлэх болон гадаад уруу хийх ашгийн шилжүүлэг нь хүнд хэцүү асуудал болж байдаг.

#### 1.1 Төлбөрийн тэнцэл ба капиталын ургал

И. Голсүрэн: Гензэл за капиталын ургал  
Капиталын ургал нь ўйлдвэрлэл болон макро эдийн засгийн менежментэд непеөлж, эдийн засгийн үр ашигтай багтаамж, хүчин чадалтай холбоотой байдаг. Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь капиталын өртөгийг нэмэгдүүлж ингэснээр боломжтой хэмжээгээр сайн сайхан байдлыг /welfare/ нэмэгдүүлж байдаг. Мөн энэ нь ерсөлдөөнтэй холбогдож технологийн түвшнийг сайжруулж байдаг.

Макро эдийн засгийн талд капиталын дотогшлох урсгал нь дотоодын валютын ханшны бодит чангарталт, эдгээр урсгалуудын мөнгөний хариу үйлдэл /money sterilization/ зэрэг хэд хэдэн менежментийн асуудлыг үүсгэж болдог. Үнэндээ энэ нь инфляцийн дарамтаас зугтаах зорилготой дотоодын зээлийн хүүг өндөр байлгахыг шаардах гадаад валютын хариу үйлдэл /foreign currency sterilization/ байдаг. Өндөр дотоодын зээлийн хүү капитальын дотогшлох урсгалыг дэмжиж, дээрх аюултай эргүүлэгт хүргэдэг. Үүнээс гадна, өндөр дотоодын зээлийн хүү болон урсгал тооцооны тэнцвэргүй байдал нь санхүүгийн зардлыг үүсгэх ба энэ нь мөн төлбөрийн тэнцлийн хямралын дохио болж байдаг. Валютын ханшны бодит чангарталт нь урсгал тооцооны тэнцлийг муутгаж байдаг.

Ийм нөхцөл байдалд капиталын хяналт нь зөвхөн валютын хямралаас зайлсхийх арга биш мөн гадаад өрийн хугацаа хоорондын тогтвортгүй байдлаас зайлсхийх арга болж байдаг. Үнэн хэрэгтээ, тухайн улс капитал дахь хяналтаа гадаад эмзэг байдал болон капиталын дотогшлох урсгалын дотоодын зардлын хосплооос хамааруулан тохируулдаг. Энэ нөхцөлд ч гэсэн валютын хямралаас зайлсхийж чадаагүй. 1995 онд Мексик, 1997 онд Азид, 1999 онд Бразил энэ эмзэг байдлын баталгаа болж егсөн.

Дээрх зүйл нь гадаад болон дотоодод капитал урсгалыг дэмжих эсвэл боогдуулдаг зүйл нь нэг юм гэдгийг баталж өгч байна. Дэлхийн зээлийн хүү нь хамгийн гол гадаад хүчин зүйл байна. Дотоод талд, капитал урсгалыг татах хүчин зүйлүүдэд хүчтэй, найдвартай мөнгөний ба сангийн бодлого болон

худалдааны ба капиталын зах зээлийн либеральчлал гэх мэт зах зээлд чиглэсэн шинэчлэлт зэрэг нь багтаж байдаг.

Тогтвортой байдал нь эргээд рискийг бууруулж, капитал урсгалыг дэмжиж байдаг. Хөгжилтэй эдийн засаг дахь буурч буй зээлийн хүү нь хөгжик буй орнууд уруу капиталыг чиглүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг ба эдгээр урсгалууд нь дээр дурдсан шинэчлэлүүдээр хязгаарлагддаггүй.

Эцэст нь халдвартай нөлөөлөл /contagious effect/ гэж байдаг. Тухайн нэг бүс нутгийн хоёр улс уруу орох капитал урсгал нь хөрш улсуудад дам нөлөө бий болгох ба нэг улс дахь гадаад хямрал бусад улсууд уруугаа тархаж болох юм.

### 1.1 Гадаад тэнцэл ба гадаад өр

Урсгал тооцооны тэнцэлгүй байдал урт хугацаанд удирдагдах боломжгүй байгаа үед гадаад өрийн тогтвортгүй хугацаа хоорондын төлөв байдал илэрч байдаг. Урсгал тооцооны зам /path/ болон түүний урт хугацаанд тогтвортгүй байдлын замд хүргэж болох боломжуудыг шалгах хэд хэдэн арга замууд байдаг. Хамгийн чухал нэг хэмжүүр ДНБ-ний хувиар хэмжсэн урсгал тооцооны алдагдал юм. Бусад аргуудад валютын ханшны динамик, халдварт нөлөөлөл болон богино хугацааны капитал урсгалын хэтрэл зэрэг байна.

Гадаад өрийн адилтгалаас:

$$D_{t+1} = (1+r_t) D_t - TB_t \quad (1)$$

Энд,  $D_t$  гадаад өр,  $r_t$  зээлийн хүү,  $TB_t$  худалдааны тэнцэл. Тэгшитгэлийн бүх гишүүнийг  $Y_t$  гэсэн нэрлэсэн ДНБ-д хуваавал:

$$d_{t+1} = \left[ \frac{1+r_t}{Y_t} \right] d_t - tb_t \quad (2)$$

$g = \frac{Y_{t+1} - Y_t}{Y_t}$  буюу ДНБ-ний өсөлтийн түвшин гэвэл:

$$(1+g)d_{t+1} = (1+r_t)d_t - tb_t \quad (3)$$

Хэрвээ гадаад өр/ДНБ-ий харьцаа тогтвортой байна гэж үзвэл  $d_{t+1} = d_t$  байна. Тэгвэл:

$$tb_t^R = (r_t - g)d_t \quad (4)$$

(4) тэгшитгэлээр шийдэгдсэн худалдааны илүүдэл нь, цаг хугацаан дахь гадаад өр/ДНБ-ий тогтвортой харьцаанд нийцэх худалдааны илүүдлийг харуулах

Шаардлагатай Худалдааны Илуүдэл /Required Trade Balance/ байна. Энэ Шаардлагатай Худалдааны Илуүдэл болон түүвэрлэгдсэн худалдааны тэнцлийн хорондын зөрүү Нөөцийн Зөрүүний Тэнцэл /Balance of Resource Gap/ байна.

### 2. Гадаад Өрийн тогвортгилтыг шинжлэх загварууд

Энэ ажилд гадаад өрийн тогвортгилтийг шинжлэх гурван аналитик хандлагыг танилцуулна. Нэгдүгээрх нь, Sawada (1994), Wilcox (1989), Hamilton and Flavin (1986) нарын ажлаас гарч ирнэ. Хоёрдугаарх нь цэвэр гадаад өрөөс гарч ирэх ба энэ нь тогвортгилтын шинжилгээний үндсэн бүтцийг зөвхөн дифференциал тэгшитгэлүүдээр харуулна. Гуравдугаарх нь, мөн Hamilton and Flavin (1986) нарын ажлаас гарч ирэх ба энд дискаунтлагдсан өрийг ашиглан шалгах тэгшитгэлийг гаргаж авна.

#### 2.1 Загвар 1

Энэ загвар нь Sawada (1994), Wilcox (1989), Hamilton and Flavin (1986) нарын ажлуудаас гарч ирсэн эмпирик үнэлэгдэх тэгшитгэл юм. Энэ нь нээлттэй эдийн засгийн түеийн үндсэн тооцооны адилтгалаас гарч ирнэ.

$$Y_t + (D_t - D_{t-1}) + TR_t = A_t + r_t D_{t-1} + \Delta RE_t \quad (5)$$

Энд,  $Y_t$  нь  $t$  үе дэх ДНБ,  $D_t$  нь цэвэр гадаад өр (нийт гадаад өрөөс хасах нь гадаад валютын нөөц),  $TR_t$  нь цэвэр мөнгөн шилжүүлэг,  $A_t$  нь дотоод зардал,  $r_t$  нь нэрлэсэн зээлийн хүү,  $\Delta RE_t$  нь гадаад валютын нөөцийн өөрчлөлт байна. Тооцооны адилтгалын тэнцүүгийн тэмдгийн зүүн тал нь эдийн засгийн нийт орлогыг илтгэж байхад баруун тал нь нийт зардлыг нь илэрхийлнэ. Нээлттэй эдийн засаг дахь орлогын адилтгалаас дараах зүйлийг олж болно.

$$X_t - M_t = Y_t - A_t \quad (6)$$

Энд,  $X_t$ ,  $M_t$  нь харгалзан  $t$  үе дэх бараа үйлчилгээний нэрлэсэн экспорт, импорт байна. (5) тэгшитгэлээс тухайн эдийн засгийн худалдааны тэнцлийг дараах байдлаар олж болно.

$$TB_t = X_t - M_t = r_t D_{t-1} - (D_t - D_{t-1}) - TR_t + \Delta RE_t \quad (7)$$

Эндээс гадаад өр нь:

$$(D_t - D_{t-1}) = r_t D_{t-1} - [TB_t + TR_t - \Delta RE_t] \quad (8)$$

$S_t = [TB_t + TR_t - \Delta RE_t]$  гэж тэмдэглэвэл дээрх адилтгалыг гадаад өрийг эргүүлэн төлөхөд ашиглаж болох цэвэр гадаад илүүдэлээр илэрхийлж байна. (8) тэгшитгэл ялгаварт тэгшитгэл ўчраас үүнийг цэвэр гадаад өр  $D_t$ -ийн "forward-looking" шийдэл нь:

$$D_t = \lim_{N \rightarrow \infty} \frac{D_N}{\prod_{j=1}^{N-1} (1+r_{t+j})} + \sum_{j=t+1}^{\infty} \frac{S_j}{\prod_{i=1}^{j-t} (1+r_{t+i})} \quad (9)$$

Тэгшитгэлийн баруун талын хоёр илэрхийллээс хүлээлтийн оператор авбал төлбөрийн чадварын нөхцлийг дараах байдлаар тодорхойлж чадна.

$$D_t = E \sum_{j=t+1}^{\infty} \frac{S_j}{\prod_{i=1}^{j-t} (1+r_{t+i})}$$

Эсвэл, хэрвээ

$$D_t = E \lim_{N \rightarrow \infty} \frac{D_N}{\prod_{j=1}^{N-1} (1+r_{t+j})} = 0 \quad (10)$$

Энэ нь "no Ponzi" нөхцөл ба өөрөөр хэлбэл, гадаад өрийн төлбөр тогтвортой байхад олон улсын зах зээл дээрх тухайн улсын зээлийн хэмжээ нь ирээдүйн худалдааны илүүдлийн өнөөгийн өртөгтэй тэнцуу байна гэсэн үг. Хэрвээ (10) тэгшитгэл тэгээс их байвал тухайн улс хугацаа нь болсон хуучин өрөө шинэ өр гаргах замаар төлж байгаа буюу гадаад өр урт хугацаанд тогтвортгүй байна гэдгийг харуулна.

Зээлийн хүү стационар,  $r$  гэсэн нөхцөлт бус дундажтай гэж үзвэл (8) тэгшитгэлээс  $rD_{t-1}$ -г хасаж болно.

$$E_t + (1+r)D_{t-1} = EX_t + D_t \quad (11)$$

Энд,  $EX_t = X_t + TR_t + RE_{t-1}$ ,  $IM_t = M_t + RE_t$ ,  $E_t = IM_t + (r_t - r)D_{t-1}$  байна. 1-р эрэмбийн ялгавар авбал:

$$\Delta D_t = \Delta E_t + (1+r)\Delta D_{t-1} - \Delta EX_t \quad (12)$$

Дээрх тэгшитгэлийн "forward-looking" шийдэл нь:

$$MM_t = EX_t + \lim_{i \rightarrow \infty} \frac{\Delta D_{t+1}}{(1+r)^i} + \sum_{j=t+1}^{\infty} \frac{\Delta EX_j - \Delta E_j}{(1+r)^{j-t}} \quad (13)$$

Энд,  $MM_t$  нь  $(M_t + rD_{t-1})$ -ээр тодорхойлогдоно.

$EX_t$  ба  $MM_t$  дрифттэй санамсаргүй (random walk) хувьсагчид өөрөөр хэлбэл, хөөулаа сүл гишүүнтэй стационар биш гэж үзвэл дараах үнэлж болохуйц эмпирик тэгшитгэлийг олж авна.

$$EX_t = a + bMM_t + u_t \quad (14)$$

Харвээ  $EX_t$  ба  $MM_t$  нар нь стационар биш процессууд бол тэг таамаглал нь  $EX_t$  ба  $MM_t$  нь cointegrated буюу  $b=1$  байна. Тийм учраас, тухайн улсын төлбөрийн чадвартай байх гарцаагүй нөхцөлд хүрэхийн тулд  $EX_t$  ба  $MM_t$  нь коинтеграци хамааралтай байх хэрэгтэй.

Энгийнээр, хоёр хувьсагч коинтеграци хамааралтай гэж, хувьсагч бүр нь тусдаа стационар биш I(1) процесс байхад тэдний шугаман хоспол стационар байх үед хэлнэ. Энд  $EX_t - a - bMM_t = u_t$  нь стационар байж болох юм.  $EX_t$  ба  $MM_t$  тус бүрд нэгж язгуурын проблем байгаа эсэхийг шалгасны дараа Johansen-ий тэстийн процедурыг ашиглан коинтеграци хамаарлын рөгресс (14)-ийг үнэлнэ.

## 2.2 Загвар 2

Орийн тогтвортой байдлыг олох өөр нэг сонголтод арга нь дараах үндсэн тэгшитгэлээс гарч ирнэ.

$$d = \frac{D}{Y} \quad (15)$$

Энд,  $D$  нь тухайн улсын гадаад өрөнд орсон байдлын өртөг,  $Y$  нь ҮНБ. Цаг хугацаагаар уламжлал авбал:

$$\frac{\dot{d}}{d} = \frac{\dot{D}}{D} - \frac{\dot{Y}}{Y} \quad (16)$$

$CA = -B + rD$  байдаг. Энд,  $CA$  нь урсгал тооцооны алдагдал,  $B$  нь цэвэр хүүгийн төлбөрийг хассан урсгал тооцооны илүүдэл болон  $r$  нь гадаад өрөнд төлж байгаа хүүгийн түвшин байна. Үүнээс:

$$\dot{D} = -B + rD$$

$$\frac{\dot{D}}{D} = \frac{-B + rD}{D}$$

$$\frac{\dot{d}}{d} = -\frac{B}{D} + r - g$$

Энд,  $g$  нь ҮНБ-ний өсөлтийн түвшин.

$$\frac{\dot{d}}{d} = (r - g) - \frac{B}{D} \quad (17)$$

Хэрвээ,  $r = g$  бол:

$$\frac{\dot{d}}{d} = -\frac{B}{D} \quad (18)$$

Хэрвээ  $r = g$  бол гадаад өрөнд орсон байдал нь хүүгийн бус ургал тооцоо нь алдагдалтай байх үед ҮНБ-тэй харилцан уялдаатай ёснэ. Нөгөө талаас, хэрвээ  $r > g$  бол тухайн улсын гадаад өр нь, хүүгийн бус ургал тооцоо гадаад өрийн өртөгтэй харьцуулахад хангалттай их илүүдэлгүй байхад ҮНБ-тэй харилцаан уялдаатай ёснэ. Тийм учраас тогтвортой төлөвийн зам нь гадаад өр, ҮНБ-ний харьцаа  $\frac{\dot{d}}{d} = 0$  байна.

Хэрвээ  $d = 0$  бол  $\frac{\dot{d}}{d} = 0$  байна. Тэгвэл:  $\frac{B}{D} = (r - g)$  болно.  $d = \frac{D}{Y}$  гэдгээ

$$\frac{D}{Y} \cdot \frac{B}{D} = (r - g)d \text{ болно. Эндээс } d^* = \left( \frac{\frac{B}{Y}}{r - g} \right) \quad (19)$$

Хэрвээ  $r > g$  байвал гадаад өр, гадаадын зээлийн хүү болон ҮНБ-ний өсөлтөн тохирсон ургал тооцооны тогтвортой алдагдлыг олох боломжгүй болно. Түүнчлэн, энэ нь  $d^* > 0$  байх үеийн гарцаагүй худалдааны илүүдлийн илэрхийлнэ.

### 2.3 Загвар 3

Загвар 1-ийн (9) болон (10) тэгшитгэлийн хуваарьт байгаа дискаунтлагдсан хүчин зүйлүүдийг дахин тодорхойлж дискаунтлагдсан өрийг ашигласан шалгах болохуйц тэгшитгэлийг гаргаж авч болно.

(б) тэгшитгэлээс:

$$D_t = (1+r_t) D_{t-1} - S_t \quad (20)$$

$Q_t = \prod_{j=0}^{t-1} (1+r_j)^{-1}$ ;  $Q_0 = 1$  гэж үзвэл (20) тэгшитгэлийг дараах байдлаар дискаунтлагдсан хүчин зүйлүүдээр үржүүлж өгч болно.

$$D_t Q_t = Q_{t-1} D_{t-1} - Q_t S_t$$

Үүнийг жижиг үсэг ашиглан бичвэл:

$$d_t = d_{t-1} - s_t \quad (21)$$

Дараалсан орлуулалт хийвэл:

$$d_t = \sum_{j=1}^N s_{t+j} + d_{t+N} \quad (21')$$

### 3. Огөгдлийн шинжилгээ, Үнэлгээ, Үнэлгээний Үр дүн

#### 3.1 Загваруудад ашиглагдах тоон өгөгдлүүд

##### Загвар 1

Дараах тэгшитгэл шалгагдана.

$$EX_t = a + bMM_t + u_t \quad (14)$$

Ургал тооцоо тогтвортой байх гарцаагүй бөгөөд хүрэлцээтэй нөхцөл нь (14) тэгшитгэл дэх цуваанууд коинтеграци хамааралтай буюу  $b = 1$  байна. Тэгвэл тест хийх эхний алхам нь хувьсагчдын стационар байдлыг шалгах явдал байна. Dickey and Fuller (1979) нар ямар нэгэн  $x_t$  цувааны хувьд нэгж язгуурын проблем байгаа эсэхийг шалгахдаа дараах тэгшитгэлийг ХБКА-аар үнэлэнэ гэж үзсэн байдал.

$$\Delta x_t = \beta_0 x_{t-1} + \sum_{i=1}^p \beta_i \Delta x_{t-i} + \varepsilon_t$$

Нэгж язгуурын проблемыг шалгах Augmented Dickey-Fuller тест нь  $x_{t-1}$ -ийн өмнөх коеффициент тэгтэй тэнцүү байгаа эсэхийг шалгаж байгаа тестээс

бүрддэг. Регрессийн өндөр-эрэмбийн авторегрессив гишүүн агуулсан байдал нь тархалтын нөхцлийн цуврал корреляцийг удирдаж байдаг.

$H_0: \beta_1 = 0$  таамаглалын дор  $x_t$  цуваа нэгж язгуурыг агуулж байх буюу стационар биш байна. Харин альтернатив  $H_1: \beta_1 < 0$  таамаглалыг хангах цуваа стационар байна. Akaike Information Criterion /AIC/ нь хувьсагчийн лаг-ийн уртыг тогтооход ашиглагдана. Phillips-Perron-ийн тест цуврал корреляцитай болон хетерокедастик алдааны нөхцөлтэй байгаа үед нэгж язгуурыг шалгадаг.

Загвар 1-т экспорт, цэвэр шилжүүлэг, гадаад нийт нөөц, импорт, дундаж хүүгийн түвшний тоон өгөгдлүүд ашиглагдана.

## Загвар 2

Энэ загварт ашиглагдах, шалгаж болохуйц тэгшитгэл нь үндсэндээ, цэвэр гадаад өр болон гадаад худалдааны тэнцлийн хоорондох коинтеграци хамаарлын векторийг олоход зориулагдсан байна. Учир нь гадаад худалдааны тэнцэл алдагдалтай байна гэдэг нь өөрсдийн үйлдвэрлэж байгаагаасаа ихийг хэрэглэж байна гэсэн үг. Үүнийг, нэгдүгээр зээлээр буюу өр тавьж, хоёрдугаарт өрийн санхүүгийн активуудыг худалдаах замаар санхүүжүүлж болдог. Тэгхээр урт хугацаанд гадаад худалдааны тэнцэл нь гадаад өрийн тогтвортой байдалд нөлөөлөгч, тодорхойлогч гол зүйл нь болно.

Энэ загварыг ашиглах эхний алхам нь цэвэр гадаад өр болон худалдааны тэнцлийн хувьд нэгж язгуурын тестийг хийхээс бүрдэнэ. Дараагийн алхам нь цэвэр гадаад өр, худалдааны тэнцлийн хооронд коинтеграци хамаарал байгаа эсэхийг шалгах Johansen-ийн тест хийх явдал байна.

Загвар 2-т гадаад худалдааны тэнцэл, нийт гадаад өр, цэвэр нийт гадаад өрийн тоон үзүүлэлтүүд ашиглагдана.

## Загвар 3

Загвар 3 нь (21) тэгшитгэлийг ашиглана. Гадаад өр тогтвортой байх гарцаагүй нөхцөл нь дискаунтлагдсан өр стационар байх явдал байна. (21) тэгшитгэл  $Q_t = \prod_{j=0}^{t-1} (1+r_j)^{-1}$ ;  $Q_0 = 1$  гэсэн дискаунтлагдсан хүчин зүйлээс гарч ирнэ.

Загвар 3-т нийт гадаад өр, төлбөрийн баланс, цэвэр шилжүүлэг, нийт гадаад нөөцийн өөрчлөлт, зээлийн хүүгийн түвшний тоон өгөгдлүүд ашиглагдана.

### 3.2 Өгөгдлийн шинжилгээ

Гадаад өрийн тогвортой байдлыг шалгах дээрх гурван загварт шаардлагатай эдийн засгийн тоон өгөгдлүүдээс гадаад зээлийн хүүгийн өгөгдөл манай улсын хувьд одоохондоо боломжгүй байна. Манай улсын хувьд ихэнх гадаад

зээлүүд нь онцгой хөнгөлөлттэй нөхцөлтэй байдаг учраас олон улсын арилжвани зээлийн хүүг авах нь загварт маань тохирохгүй юм. Тийм учраас 1 ба 3-р загварыг ашиглан гадаад өрийн тогтвортой байдлыг шалгах ажил боломжгүй болж байна.

Харин 2-р загварт шаардлагатай гадаад худалдааны баланс, цэвэр нийт гадаад өрийн 1991-2001 оны үзүүлэлт боломжтой байна. Нийт өрийн үзүүлэлтийг авахдаа 1991 оноос хойших үеийг авсан. 1990 оноос өмнөх үеийн гадаад өрийг авч үзээгүй учир нь, нэгдүгээрт, төлөх эсэх нь шийдэгдээгүй, хоёрдугаарт өөр эдийн засгийн системд бий болсон учраас өнөөгийн эдийн засгийн төлөв байдлаар тайлбарлагдахгүй, гуравдугаарт цаг хугацааны динамик, тогтвортой төлөв байдлыг судалж байгаа учраас тогтмол байгаа өмнөх гадаад өрийн хэмжээ онцгой нөлөө үзүүлэхгүй гэж үзсэн.

Цэвэр нийт өр, гадаад худалдааны балансын өгөгдлийн цуваанд нэгж язгуурын проблем байгаа эсэхийг Augmented Dickey-Fuller-ийн тестээр шалгасан үр дүн дээрх хүснэгтэнд байна

### Цэвэр нийт гадаад өр

	Lag.dif	Constant		Constant and trend		None		Order
		Level	Dif	Level	Dif	Level	Dif	
Net debt	0	-0.323611	-2.629649	-1.797297	-2.414870	<b>2.510370*</b>	-1.647345	I(0)
	1	-0.342508	-1.700819	-2.032248	-1.492678	1.252599	-1.001098	
	2	0.060629	-2.221127	-3.109916	-1.903182	1.000381	-0.992016	
	3	0.432691	-2.536359	-2.827354	-2.827354	1.765368	-0.332058	

\* 5%-ийн итгэх түвшинтэй нэгж язгуурын таамаглалын няцаалт

\*\* 1%-ийн итгэх түвшинтэй нэгж язгуурын таамаглалын няцаалт

### Худалдааны баланс

	Lag. dif	Constant		Constant and trend		None		Order
		Level	Dif	Level	Dif	Level	Dif	
Trade balance	0	-1.859327	<b>-4.379112*</b> AIC=12.2361	-3.086274	<b>-4.413823*</b> AIC=12.3288	-1.459720	<b>-4.566370**</b> AIC=12.0508	I(1)
	1	-0.916330	-3.147278	-2.689179	-3.575262	-0.539036	<b>-3.133805**</b> AIC=12.2654	I(1)
	2	-0.151248	-2.987506	-3.516166	-2.418572	0.252260	-1.870849	
	3	0.245987	-2.036938	-1.402980	-1.402980	0.789648	-0.563377	

\* 5%-ийн итгэх түвшинтэй нэгж язгуурын таамаглалын няцаалт

\*\* 1%-ийн итгэх түвшинтэй нэгж язгуурын таамаглалын няцаалт

Ох үүсвэр: EVIEWS програмын үнэлгээ

Цэвэр нийт гадаад өр, худалдааны балансын ADF тестийн үр дүнгээс харахаа цэвэр гадаад өр нь I(0) процесс буюу шууд стационар байна. Гадаад өрийн тогтвортой байдлыг тогтоох коинтеграци хамаарлыг шалгахад өгөгдлийн цува I(0) процесс байх шаардлагатай тул цэвэр гадаад өрийг цаашид ашигла боломжгүй болж байна. Иймээс гадаад өрийн үзүүлэлтээр нийт гадаад өрийн авч шинжилгээг хийх болно. Нийт гадаад өр, цэвэр гадаад өрийн өрөнхи хандлага, өөрчлөлт нь адил учраас ашиглах боломжтой гэж үзэж байна.

Харин худалдааны балансын хувьд дөрвөн төрлийн ялгаварт стационар байх хэлбэр илрэч байгаа ба эдгээрээс чухам аль нь илүү нийцтэй илэрхийл байгааг тодорхойлохын тулд эдгээр загваруудын Akaike Information Criteria /AIC/ үзүүлэлтүүдийг хооронд нь жишихэд сул гишүүнгүй нэгдүгээр эрэмбийн ялгаварт стационар хэлбэрийн AIC үзүүлэлт хамгийн байгаа байна. Ийм учраас худалдааны тэнцлийн өгөгдлийн цуваа сул гишүүнгүй I(1) процесс байна.

#### Нийт гадаад өр

	Lag.dif	Constant		Constant and trend		None		Order
		Level	Dif	Level	Dif	Level	Dif	
Debt	0	-0.474390	-3.223374	-2.029267	-2.987438	2.759062*	AIC=11.3196	I(0)
	1	-0.218213	-1.669459	-1.976484	-1.358500	1.687622	0.928006	
	2	0.000223	-2.450377	-3.955957	-1.613559	0.735742	0.926732	
	3	0.090985	-7.563975**	-7.265537**	-7.265537**	1.366871	0.407674	I(1)

\* 5%-ийн итгэх түвшинтэй нэгж язгуурын таамаглалын няцаалт

\*\* 1%-ийн итгэх түвшинтэй нэгж язгуурын таамаглалын няцаалт

Эх үүсвэр: EVIEWS програмын үнэлгээ

Нийт гадаад өрийн ADF тестийн үр дүнгээс харахад сул гишүүн, 3 хоцрогдолтоо ялгаварт гишүүнтэй I(1) процесс байна.

### 3.3 Гадаад өрийн тогвортой байдлын үнэлгээ

Худалдааны балансын өгөгдлийн цуваа болон нийт гадаад өрийн өгөгдлийн цуваа нь хоёул адил I(1) процесс байгаа учир уг хоёр хувьсагчийн хооронд урт хугацааны тэнцвэр буюу гадаад өр урт хугацаанд тогвортой төлөв байдал, орох эсэхийг Johansen-ийн коинтеграцийн тестийг ашиглан шалгаж болно.

Хэрвээ уг хоёр хувьсагчийн хооронд урт хугацааны хамаарал буюу коинтеграци хамаарал оршин байвал гадаад өр урт хугацаанд гадаад худалдааны илүүдлээр санхүүжигдэж, гадаад өрийн өсөлтийн хурдац зогсох буюу гадаад өр тогвортой төлөвлөө хүрнэ гэсэн уг. Өөрөөр хэлбэл, гадаад өрийг худалдааны балансаар удирдаж зохицуулж болно гэсэн уг.

#### Johansen-ийн коинтеграци хамаарлын тестийн үр дүн (no deterministic trend in the data)

Eigenvalue	Likelihood Ratio	5 Percent Critical Value	1 Percent Critical Value	Hypothesized No. of CE(s)
0.720954	16.65625	19.96	24.60	None
0.436910	5.168842	9.24	12.97	At most 1

\*(\*\*) denotes rejection of the hypothesis at 5%(1%) significance level  
L.R. rejects any cointegration at 5% significance level

Eigenvalue	Likelihood Ratio	5 Percent Critical Value	1 Percent Critical Value	Hypothesized No. of CE(s)
0.720954	16.65625	19.96	24.60	None
0.436910	5.168842	9.24	12.97	At most 1

\*(\*\*) denotes rejection of the hypothesis at 5%(1%) significance level  
L.R. rejects any cointegration at 5% significance level

Eigenvalue	Likelihood Ratio	5 Percent Critical Value	1 Percent Critical Value	Hypothesized No. of CE(s)
0.715999	11.97353	15.41	20.04	None
0.069110	0.644527	3.76	6.65	At most 1

\*(\*\*) denotes rejection of the hypothesis at 5%(1%) significance level  
L.R. rejects any cointegration at 5% significance level

Eigenvalue	Likelihood Ratio	5 Percent Critical Value	1 Percent Critical Value	Hypothesized No. of CE(s)
0.719158	17.23359	25.32	30.45	None
0.475274	5.803916	12.25	16.26	At most 1

\*(\*\*) denotes rejection of the hypothesis at 5%(1%) significance level  
L.R. rejects any cointegration at 5% significance level

Eigenvalue	Likelihood Ratio	5 Percent Critical Value	1 Percent Critical Value	Hypothesized No. of CE(s)
0.682861	16.03983	18.17	23.46	None
0.469422	5.704089	3.74	6.40	At most 1 *

\*(\*\*) denotes rejection of the hypothesis at 5%(1%) significance level  
L.R. rejects any cointegration at 5% significance level

Дээрх тестийн үр дүнгээс харахад коинтеграци хамаарлын ямар ч хэлбэр дээр өвөгдлийн утгаар тооцсон тооцооны утга маань критик утгаа давж чадахгүй байгаа учраас гадаад худалдааны тэнцэл ба нийт гадаад өрийн хооронд урт хугацааны тэнцвэр байхгүй байна. Өөрөөр хэлбэл манийн улсын 1991-2001 оны

хоорондох гадаад өр болон худалдааны тэнцлийн алдагдал урт хугацаанд тогтвортгүй байна. Нийт гадаад өр, гадаад худалдааны тэнцэл хоёрын хооронд урт хугацааны коинтеграци хамаарал байхгүй байгаа учраас загварын тавил ёсоор гадаад өрийн өсөлтийн хурдац тэг уруу нийлэхгүй. Өөрөөр хэлбэл, манай улсын гадаад өрийн өсөлт зогсохгүй, цаашдаа нэмэгдэх хандлагатай байна гэсэн үг.

Хэрвээ их хэмжээний хуримтлагдсан гадаад өрийн өртөг нь зээлийн хүүгийн ямар нэгэн шоктой учирвал ургсал тооцооны алдагдалыг удирдах боломжгүй болгохоос гадна гадаад өрийн төлбөрийг хийх боломжийг байхгүй болгоно.

#### 4. ДҮГНЭЛТ, САНАЛ

- Гадаад өр урт хугацаанд тогтвортгүй байна гэсэн дээрх үр дүнд хүрэхэд манай улсын гадаад өрийн удирдлага, статистик мэдээллийг бүрдүүлэх тогтолцоо сайн бүрэлдэж тогтоогүй, уг тогтолцооноос гарч байгаа тоо мэдээллийн хангалтгүй, дутуу, буруу тооцоолсон байдал нелөөлсэн байж болох юм. 1990-ээд оноос хойш гадаад өрийг таван өөр газар удирдах байсан нь үүнийг нотолгоо юм.
- Тэгэхээр гадаад өрийн тогтвортой байдалд хүрэхийн тулд хамгийн түрүүнд өндөр хөгжилтэй болон хөгжиж буй бусад улсуудын жишээгээр гадаад өрийн үр ашигтай удирдлага, гадаад өрийн статистикийн арга аргачлалыг нэвтрүүлэх хэрэгтэй. Үүний тулд
  - ❖ НҮБ-ийн Худалдаа ба Хөгжлийн Зөвлөл /UNCTAD/-аас гаргасан “Өрийн Удирдлага болон Санхүүгийн Шинжилгээний Систем” (UNCTAD, The DMFAS Programme) хөтөлбөрт хамрагдах эсвэл уу хөтөлбөрийн болон бусад адилтгах онолын болон практик аргачлалыг өөрийн орны онцлогт тохируулан буулгаж гадаад өрийн үр ашигтай удирдлага, удирдлагын бүтэц зохион байгуулалт чадварыг бий болгох
  - ❖ Олон Улсын Валютын Сан /IMF/, Дэлхийн Банк /World Bank/, Парисын Клуб /Paris Club/ зэрэг олон улсын санхүүгийн 6 байгууллагаас хамтран гаргасан “Гадаад өрийн статистик: Эмхэтгэгч болон Хэрэглэгч наарт зориулсан удирдамж” (“External Debt Statistics: Guide for compilers and users”, Bank of International Settlements, The Commonwealth Secretariat, Eurostat, IMF, OECD, Paris Club Secretariat, UNCTAD, WB) –ыг судалж өөрийн орны гадаад өрийн статистик аргачлалыг боловсруулж, олон улсын жишигт нийцсэн гадаад өрийн мэдээллийн санг бий болгох
- Дээрх зүйлүүдийг хийсний дараах гадаад өрийн удирдлагын тогтолцооноос гарч ирэх гадаад өрийн тоон мэдээллийг ашиглан сүүлийн үеийн эдийн засгийн онолын загварууд, эконометрикийн аппаратыг ашиглан гадаад

өрийн тогтвортгилтийг шинжилж цаашдын урт хугацааны гадаад өрийн стратегийг боловсруулж удирдлагын шийдвэрт оруулж хэрэгжүүлэх нь гадаад өрийн дарамт, гадаад өрийн төлбөрийн хүндрэлээс үүсэх бусад хямралуудаас зайлсхийхэд хамгийн зөв алхам болно.

#### АШИГЛАСАН НОМ, МАТЕРИАЛ

- Frederico G.Jayne Jr “External debt sustainability: Empirical evidence Brazil”, June 2001  
 Alfredo Schclarek Curutchet “Debt sustainability in Argentina”, Jan 2002  
 Fernando de Holanda Barbosa, Manuel Sanchez la Cal “Brazilian experience with external debt and prospects for growth”, Sep 1987  
 UNCTAD, DMFAS Program: “Effective Debt Management”  
 Bank of International Settlements, The Commonwealth Secretariat, Eurostat, IMF, OECD, Paris Club Secretariat, UNCTAD, WB “External Debt Statistics: Guide for compilers and users”, Nov 2001  
 William Griffiths, R.Carter Hill and George J.Judge “Learning and practicing econometrics”, 1993, John Wiley & Sons, Inc  
 William H.Greene “Econometric Analysis”, 1997, Prentice Hall, Inc  
 R.L.Thomas “Modern Econometrics”, 1997, Addison-Wesley  
 “The New Palgrave: Econometrics”, 1990, The Macmillan Press Limited